

МӨРДӨН БАЙЦААХ ГАЗРЫН 2016 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Мөрдөн байцаах газар Монгол Улсын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол, шийдвэр, цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээ, албанаас дэвшүүлсэн зорилт, гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажлын үр дүн, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг чанд сахиж, гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон иргэдийн эрхийг хангах, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэж, алба хаагчдын ажлын хариуцлага, харьцааны соёл, ёс зүйг төлөвшүүлэх чиглэлийг үйл ажиллагаандаа чанд хэрэгжүүлж ажиллалаа.

2016 онд Мөрдөн байцаах газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гарган, эхний 12 сарын байдлаар, даргын зөвлөлийг 13 удаа хуралдуулан 251 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн.

Тайлангийн хугацаанд газрын даргын 100 тушаал гаргаснаас байгууллагын үндсэн ажлын чиглэлээр 51, боловсон хүчний чиглэлээр 49 тушаал гарсан.

1.1.Удирдах байгууллага, албан тушаалтанд мэдээлэл, танилцуулга хүргүүлсэн байдал.

2015-2016 онд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 1 гомдол, эрүүгийн 13 хэрэгт шинжилгээ, аудитын дүгнэлт, үнэлгээ хийлгүүлж эцэслэн шийдвэрлэхэд шаардлагатай 164.4 сая төгрөгний зардлын тооцооллыг гарган Сангийн сайдын 2014 оны “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилалд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардал”-ыг шинээр тусгуулах санал, зардлын тооцоог улсын төсөвт суулгуулахаар холбогдох газарт хүргүүлсэн байна. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардлын асуудал шийдвэрлэгдээгүйгээс 1 гомдол, 20 эрүүгийн хэрэгт 548,020,000 төгрөгний байцаан шийтгэх ажиллагааны зардлыг оролцогчидоор төлүүлж нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгт хавсарган шийдвэрлэсэн .

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 27 дугаартай тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагаас иргэн /хуулийн этгээд/-д мэдээлэл, лавлагаа олгох журам”-ын дагуу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд шаардлагатай лавлагаа мэдээлэл гаргаж өгөхгүй байх нөхцөл бүрдсэн нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүндрэл учруулахаар байх тул Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгуулах талаарх саналыг хүргүүлэн Цагдаагийн ерөнхий газар Нийгмийн даатгалын ерөнхий газартай харилцан мэдээлэл солилцох тухай гэрээний төсөл, мөн Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах албаны даргын энэ оны 02 дугаар сард 6/521 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу тус газраас энэ оны 03 дугаар сард хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулгыг бэлтгэн Нийтийн хэв журам хамгаалах албанд албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, гэмт хэрэг илрүүлэх, эрэн сурвалжлах чиг үүргээ хэрэгжүүлж албан хэрэгцээнд ашиглахад зориулж улсын хэмжээнд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүний амь нас хохирсон 78 хэрэг, сураггүй алга болсон 195 хүн, онц хүнд гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байгаа 13 оргодлын мэдээлэл багтсан нийт 280 хуудас бүхий “Гэмт хэргийн лавлагаа III”

номны эх бэлтгэлийн ажлыг хийж дуусган шаардагдах төсөв тооцоог гаргаж зардлын асуудлыг шийдвэрлүүлэн хэвлүүлсэн.

Улсын хэмжээнд үйлдэгдсэн Фэйсбүүк, твиттер, цахим хаяг ашиглан бусдыг залилан мэхлэх, гүтгэх, доромжлох гэмт хэргийн шинжтэй 78 гомдол мэдээлэл, эрүүгийн 16 хэрэгт Эрүүгийн Цагдаагийн газартай хамтран судалгаа хийж цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулсан.

Хоёр. Цагдаагийн байгууллагаас 2016 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн талаар

2.1. Хүний нөөцийг сонгон шалгаруулах, үнэлэх тогтолцоог боловсронгуй болгож, мэргэжлийн болон давтан сургалтын чанар, үр дүнд ахиц гаргах.

Иргэн, алба хаагчийг сонгох, судлах, томилохдоо Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Албан тушаалд томилох болзол, шаардлага, шалгуур /код 901/-ыг баримтлан баримт бичгийг бүрдүүлж, 113 алба хаагчийн баримт бичгийг Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Хууль Сахиулахын их сургуулийн магистрын сургалтанд 1, доктрантурын сургалтанд 3, Монголын Үндэсний дээд сургуулийн магистрын сургалтанд 1, Цэцээ гүн дээд сургуулийн магистрын сургалтанд 1 алба хаагч тус тус хамрагдан суралцсан.

Мөрдөн байцаах газрын алба хаагчдад ахлах сэтгэл зүйч-полиграфич О.Оюунбилэг алба хаагчдад “Тархиа хөгжүүлэх нь”, Нийслэлийн онцгой байдлын газрын ахлах байцаагч н.Тамир “Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх”, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ахлах байцаагч, ахмад П.Элбэгсайхан “Гамшиг ослын үед алба хаагчын аюулгүй байдал, байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх”, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор профессор Л.Оюун “Мөнгөн хадгаламж ба мөнгөн хуримтлал”, Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвийн их эмч Н.Уянга “Стресс, түүнээс урьдчилан сэргийлэх нь” Хүний эрхийн үндэсний комиссын өргөдөл, гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга н.Ихтамир “Байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх”, Архивын ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Б.Болд “Байгууллагын албан хэрэг хөтлөлт, анхаарах зүйл”, Авлигатай тэмцэх газрын ХШДША-ны комиссар н.Мөнхбаяр “Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн зөв бөглөх”, ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч Э.Мөнхдэлгэр “Цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах”, Элэгний төвийн сургалт, олон нийттэй харилцах албаны ажилтан Б.Баярчимэгийг урьж алба хаагчдад “Элэгний өвчлөл ба урьдчилан сэргийлэх арга” сэдвээр, мөн Цагдаагийн алба хаагчаас саатуулах байранд албан үүрэг гүйцэтгэхдээ ажлын хариуцлага алдсан асуудлаар бэлтгэсэн сургалтын видео материалыг нийт алба хаагчдад танилцуулж, нийт 20 цагийн сургалт явуулж, алба хаагчид бүрэн хамрагдсан.

Алба хаагчдыг гадаад хэлний сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулж, Хууль сахиулах их сургуулийн гадаад хэлний сургалтын төвийн 3 сарын англи хэлний сургалтанд 1, мөн сургуулийн англи хэлний онлайн сургалтанд 1, Катар Улсад араб хэлний 6 сарын сургалтанд давхардсан тоогоор 2 алба хаагч Зэвсэгт хүчний жанжин штабаас зохион явуулсан 3 сарын англи хэлний сургалтанд 1 буюу нийт 5 алба хаагч сургалтанд хамрагджээ.

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Тайвань Улсад “Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны менежмент, манлайлал” сэдвээр зохион байгуулагдсан сургалтанд 2, Арабын Бүгд Найрамдах Египет Улсад зохион байгуулагдсан “Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт сургалтанд 4, БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулагдсан “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах нь” сэдэвт сургалтанд 1, Монгол Улс, олон улсын хууль хэрэгжүүлэх хамтын ажиллагаа сэдэвт сургалтанд 2, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2, Катар Улсад зохион

байгуулагдсан араб хэлний 6 сарын сургалтанд 1, 3 сарын давтан сургалтанд 1, нийт 13 алба хаагч гадаад улсад зохион байгуулагдсан сургалтанд хамрагдсан.

Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт, түүнийг шийдвэрлэж буй байдлын талаар

Мөрдөн байцаах албаны хэмжээнд:

2016 онд иргэд, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй нийт 37720 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 14985 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн, 19529 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 2284 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэн одоо 922 гомдол, мэдээлэл хуулийн хугацаандаа шалгагдаж байгаа ба шалгасан гомдол мэдээллийн 36798-г буюу 97,5 хувийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн.

Нийт шалгасан гомдол, мэдээллийг урьд оны мөн үетэй харьцуулахад 2534 буюу 7,2 хувиар, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан гомдол, мэдээлэл 3160 буюу 19,3 хувиар тус тус өсч, эрүүгийн хэрэг үүсгэсэн гомдол, мэдээлэл 1078 буюу 6,7 хувиар, үлдэгдэл гомдол мэдээлэл 296 буюу 24,3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд 134 тэрбум 240 сая төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 60,7 хувийг буюу 81 тэрбум 180 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор 17 тэрбум 60 сая төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалав.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор мөрдөн байцаагчийн мэдэгдэл 6967 бичиж 6587 буюу 94,5 хувьд нь хариу авч ажилласан. Үүнийг өнгөрсөн үеийн мөн үетэй харьцуулахад бичсэн мэдэгдэл 125 хувиар буюу 1,7 хувиар, хариу авалт 637 буюу 10,7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Дэлхийн байгаль хамгаалах сан Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хууль бус ан, ангийн гаралтай түүхий эд худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 2016 онд хамтран ажиллах төлөвлөгөө гарган, 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдөр БОНХАЖЯ, ЛАСН-тай хамтран “Монгол Улсын зэрлэг амьтны хууль бус худалдааг бууруулах” сэдэвт төслийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцож зэрлэг амьтдын хууль бус агнууртай тэмцэх ажилд учирч байгаа хүндрэл бэрхшээл тэдгээрийг арилгах арга зам, авах арга хэмжээний талаар хэлэлцэн, хамтран ажиллахаар төлөвлөгөөний төсөл, мөн WWF/-тай хамтран “Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих”, “Ойн тухай хууль тогтоомж зөрчих”, “Ашигт малтмалын тухай хууль тогтоомж зөрчих” гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх зорилгоор телевизийн 2 минутын шторк бэлтгэн, энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээлэл хүлээн авах утасны дугаартай боршуур /200 ширхэг/-ийг хэвлүүлэн, олон хүн цуглардаг газруудад байршуулж, хууль бус агнуур, хууль бусаар мод бэлтгэх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус бүр 20-28 секундын хугацаатай шторк бэлтгэн Төв, орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлэн, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, БОНХАЖЯ-тай хамтран байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, түүний дотор зэрлэг амьтдын хууль бус агнууртай холбоотой хэргийн талаар сургалт зөвлөгөөнийг 02 дугаар сарын 19-ний өдөр Ховд аймагт зохион байгуулсан.

Хууль бус ангийн талаар иргэдээс мэдээлэл авах утсыг Дэлхийн байгаль хамгаалах сан WWF/-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас шилжүүлэн авч Мөрдөн байцаах газрын 1 дүгээр байрны жижүүр дээр байрлуулсан.